

БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙД, ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН
САЙДЫН ХАМТАРСАН ТУШААЛ

2023 оны 10 сарын 26 өдөр

Дугаар А/356 А/371

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 2, Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын батлан хамгаалах тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.9, 14.1.14, Зэвсэгт хүчний тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.10, мөн хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.22 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 1993 оны 99 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Цэргийн зориулалттай тэсэрч, дэлбэрэх зүйлийн хайгуул, устгалын ажлыг зохион байгуулах журам”-ыг хавсралтаар баталсугай.
2. “Цэргийн зориулалттай тэсэрч дэлбэрэх зүйлийн хайгуул устгалын ажлыг зохион байгуулах журам”-д нийцүүлэн холбогдох заавар боловсруулан баталж мөрдүүлэхийг Зэвсэгт хүчний Жанжин штаб (хошууч генерал С.Ганбямба)-т хариуцуулсугай.
3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Батлан хамгаалах яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар (хурандаа Н.Пүрэвдорж), Хууль зүй, дотоод хэргийн яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар (Б.Мөнхбаяр)-т тус тус даалгасугай.
4. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Батлан хамгаалахын сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 1993 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн “Журам батлах тухай” 338/131 дүгээр хамтарсан тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

БАТЛАН ХАМГААЛАХЫН
САЙД
Г.САЙХАНБАЯР

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН
САЙД
Б.ЭНХБАЯР

Батлан хамгаалахын сайд, Хууль зүй, дотоодын
хэргийн сайдын 2023 оны 10 дугаар сарын
26-ны өдрийн 4956/АБЗ дугаар хамтарсан
тушаалын хавсралт

ЦЭРГИЙН ЗОРИУЛАЛТТАЙ ТЭСЭРЧ, ДЭЛБЭРЭХ ЗҮЙЛИЙН ХАЙГУУЛ, УСТГАЛЫН АЖЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь цэргийн зориулалттай тэсэрч, дэлбэрэх зүйлийг эрж хайх, илрүүлэх, устгах, аюулгүй болгох хуульд заасан чиг үүргийг хэрэгжүүлэхдээ байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгийг хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2. Монгол Улсын нутаг дэвсгэрт цэргийн зориулалттай тэсэрч, дэлбэрэх зүйлийг хайх, илрүүлэх, аюулгүй болгох, устгах ажлыг зохион байгуулж, хэрэгжүүлэхэд энэхүү журмыг дагаж мөрдөнө.

1.3. Журмын үйлчлэлд өмчийн хэлбэр харгалзахгүйгээр байгууллага, аж ахуйн нэгж, иргэд хамаарна.

Хоёр. Нэр томьёоны тодорхойлолт

2.1. Энэ журамд хэрэглэсэн дараах нэр томьёог доор дурдсан утгаар ойлгоно.

2.1.1. цэргийн зориулалттай тэсэрч, дэлбэрэх зүйл (цаашид “тэсэрч дэлбэрэх зүйл” гэх) гэж гадны хүчний үйлчлэлээр агшин зуурын хугацаанд урвалд орж, өндөр даралт үүсгэн дулаан ялгаруулах химийн нэгдэл буюу механик хольц бүхий нисэх онгоцны бөмбөг, бүх төрлийн сум, мина, пуужин, гранат, тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл, зарим төрлийн хүчтэй пиротехникийн хэрэгслийг;

2.1.2. цэргийн зориулалттай тэсэрч, дэлбэрэх зүйлийн хайгуул, устгалын бүлэг (цаашид “хайгуул, устгалын бүлэг” гэх) гэж Зэвсэгт хүчний нэгтгэл, ангид томилгоожиж, тэсэрч, дэлбэрэх зүйлийг хайн илрүүлж таних, аюулгүй болгох, устгах мэргэжлээр бэлтгэгдсэн, тусгай техник, хэрэгсэл (хамгаалалтын хувцас, дуулга, агсамж, тусгай багаж хэрэгсэл, эрэлч нохой, бусад материал)-ээр хангагдсан орон тооны болон орон тооны бус бүлэг, тоот, тасаг, салаа хүртэлх хүчийг;

2.1.3. “цэргийн зориулалттай тэсэрч, дэлбэрэх зүйлийн хайгуул, устгалын ажил” (цаашид “хайгуул, устгалын ажил” гэх) гэж тэсэрч, дэлбэрэх аюул бүхий зүйлийг хайн илрүүлэх, таних, тэмдэглэх, аюулгүйн зайд шилжүүлэн тээвэрлэх, аюулгүй болгох, саармагжуулах, устгах ажиллагааг;

2.1.4. “орон тооны бүлэг” гэж тайван цагийн орон тоогоор чиг үүргээ гүйцэтгэж байгаа бүлгийг;

2.1.5. “орон тооны бус бүлэг” гэж ЗХЖШ болон төрлийн цэргийн командлагч, удирдах газрын дарга нарын “Бэлэн байдлыг хангах удирдамж”-ийн дагуу хайгуул, устгалын үүрэг гүйцэтгэх бүлгийг.

Гурав. Хайгуул, устгалын ажлыг гүйцэтгэх зарчим

3.1. Тэсэрч, дэлбэрэх зүйлийн хайгуул, устгалын ажлыг гүйцэтгэхэд дараах зарчмыг баримтлана:

- 3.1.1. аюулгүйн ажиллагааны дүрэм, зааврыг чанд сахин мөрдөх;
- 3.1.2. шуурхай арга хэмжээ авах;
- 3.1.3. хүн ам, эд хөрөнгө, хүрээлэн буй орчинд хор хөнөөл учруулахгүй байх;
- 3.1.4. тусгай зориулалтын техник, хамгаалах хэрэгсэл ашиглах;
- 3.1.5. нэгдмэл, төвлөрсөн удирдлагатай байх.

Дөрөв. Хайгуул, устгалын ажлын удирдлага, зохион байгуулалт

4.1. Зэвсэгт хүчний Жанжин штаб хайгуул, устгалын ажлыг мэргэжлийн удирдлагаар хангана.

4.2. Монгол Улсын нутаг дэвсгэрт цэргийн зориулалттай тэсэрч, дэлбэрэх зүйл илэрсэн, орхигдсон байж болзошгүй нутаг дэвсгэрт эрэл хайгуул хийх, аюулгүй болгох, устгах үүргийг Зэвсэгт хүчний Жанжин штабын зөвшөөрлөөр зөвхөн тусгай томилгоот хайгуул, устгалын бүлэг гүйцэтгэнэ.

4.3. Цэргийн зориулалттай тэсэрч, дэлбэрэх зүйлийн хайгуул, устгалын ажиллагааг төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус гэж ангилна.

4.3.1. төлөвлөгөөт хайгуул устгалын ажлыг Зэвсэгт хүчний Жанжин штаб тухайн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгаж, шаардагдах зардлыг жилийн төсөвтөө тусган хэрэгжүүлнэ.

4.3.2. төлөвлөгөөт бус хайгуул, устгалын ажлыг мэдээлэл болон хүсэлт ирсэн тухай бүрт энэ журмын 4.6-д заасан мэдээллийг үндэслэн хэрэгжүүлнэ.

4.4. Байгууллага, хуулийн этгээд, иргэн нь тэсэрч, дэлбэрэх зүйл орхигдсон байж болзошгүй болон илэрсэн тухай мэдээллийг тухайн Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн Онцгой байдлын болон Цагдаагийн байгууллага (газар, хэлтэс, хэсэг)-д мэдэгдэж, хайгуул, устгалтын ажил хийлгэх хүсэлтээ Онцгой байдлын болон Цагдаагийн байгууллагаар дамжуулан Зэвсэгт хүчний Жанжин штабт 12 цагаас ихгүй хугацааны дотор ирүүлнэ.

4.5. Онцгой байдлын болон Цагдаагийн байгууллага нь тэсэрч, дэлбэрэх зүйл илэрсэн тухай мэдээллийн дагуу энэ журмын 5.3-т заасан чиг үүргийг хэрэгжүүлж, тухайн газар оронд олон нийтийн аюулгүй байдлыг хангах арга хэмжээг яаралтай зохион байгуулна.

4.6. Хайгуул, устгалын бүлэг ажиллуулах хүсэлтэд дараах агуулгыг багтаана.

- 4.6.1. тэсэрч, дэлбэрч болзошгүй зүйлийг хэн, хэзээ, хаанаас илрүүлсэн;
- 4.6.2. илрүүлсэн тухай хэзээ, хэнд, хэрхэн мэдэгдсэн;
- 4.6.3. тэсэрч, дэлбэрэх зүйлийн фото зураг, дүрс бичлэг, байршил зэрэг болно.

4.7. Байгууллага, хуулийн этгээдээс ирүүлсэн хүсэлтийн дагуу тэсэрч, дэлбэрэх зүйлийн хайгуул, устгалын ажлыг тухайн байгууллага, хуулийн этгээдтэй гэрээ байгуулж, төлбөрийг гаргуулна.

4.8. Зэвсэгт хүчний Жанжин штабын зөвшөөрлийн дагуу байгууллага, хуулийн этгээдтэй ЗХЖШ-ыг төлөөлөн нэгтгэл, ангийн захирагч хайгуул, устгалын ажил гүйцэтгэх тухай гэрээ байгуулж, хамтран ажиллана.

4.9. Гэрээнд тухайн ажлын хэмжээ, гүйцэтгэх хугацаа, талуудын хүлээх үүрэг, хариуцлага, маргаан шийдвэрлэх журам, аюулгүй байдлыг хангах арга хэмжээ, шаардагдах зардлын тооцоо, ажлын хөлс, төлбөр барагдуулах журам зэргийг тусгана.

4.10. Зэвсэгт хүчний Жанжин штаб нь тэсэрч, дэлбэрэх зүйл илэрсэн тухай мэдээллийн дагуу мэргэжлийн дүгнэлт гаргах, хайгуул, устгалын бүлгийг ажиллуулах шийдвэрийг гаргаж, хайгуул, устгалын ажлыг мэргэжлийн удирдлагаар хангана.

4.11. Хайгуул, устгалын ажлын нэгдсэн төлөвлөлтийг ЗХЖШ-ын тэсэрч, дэлбэрэх зүйлийн мэргэжилтэн боловсруулж, гүйцэтгэлд хяналт тавих ба хэрэгжилтийг Төрлийн цэргийн командлалын Инженерийн дарга, офицер, Удирдах газрын Ерөнхий инженер, Нэгтгэл, ангийн Инженерийн албаны дарга хариуцна.

4.12. Хайгуул, устгалын ажлыг гүйцэтгэсэн, тэсэрч дэлбэрэх зүйлийг хайн илрүүлж, аюулгүй болгон устгасан тухай актыг журмын нэгдүгээр хавсралтад заагдсан маягтын дагуу хайгуул, устгалын бүлэг үйлдэж, томилон ажиллуулсан нэгтгэл, ангийн захирагчаар баталгаажуулан гаргасан зардал, галт хэрэглэлийн тооцоог Зэвсэгт хүчний Жанжин штабт хүргүүлнэ.

4.13. Тэсэрч, дэлбэрэх зүйл, хайгуул, устгалын ажлын явц, үр дүнгийн тухай болон ард иргэдэд сэрэмжлүүлэг өгөх мэдээллийг зөвхөн ЗХЖШ-ын даргын тушаалаар баталгаажсан “Зэвсэгт хүчний хэвлэл олон нийттэй харилцах журам”-ын дагуу олон нийтийн мэдээллийн хэрэгслээр хүргэнэ.

Тав. Байгууллага болон хуулийн этгээд, иргэний эрх үүрэг

5.1. Зэвсэгт хүчний Жанжин штабын эрх, үүрэг:

5.1.1. хайгуул, устгалын бүлгийн сургалт бэлтгэл, бэлэн байдлыг хангаж, бүх төрлийн хангалтыг зохион байгуулан бүлгийн үүрэг гүйцэтгэх нөхцөлийг бүрдүүлэх;

5.1.2. эрсдэл бүхий нутаг дэвсгэрт тэсэрч, дэлбэрэх зүйлийн хайгуул, устгалын ажил явуулах нэгдсэн төлөвлөгөө боловсруулж, хэрэгжилтийг зохион байгуулах;

5.1.3. хайгуул, устгалын бүлгийн ажиллах зааврыг баталж, мөрдүүлэх;

5.1.4. хайгуул, устгалын бүлгийг ажиллуулах тушаал гаргаж, хэрэгжилтийг зохион байгуулах;

5.1.5. хайгуул, устгалын ажил гүйцэтгэх үед цэргийн алба хаагч гэмтсэн, эрүүл мэнд нь хохирсон тохиолдолд “Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай” болон бусад хууль тогтоомжид нийцүүлэн хөнгөлөлт, нөхөн төлбөр, урамшуулал олгох.

5.2. Орон нутгийн засаг захиргааны байгууллага, түүний удирдлагын эрх, үүрэг

5.2.1.тэсэрч, дэлбэрэх зүйл илэрсэн буюу осол гарсан тохиолдолд байршлыг хамгаалалтад авч, хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгийг хамгаалах, нүүлгэн шилжүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

5.2.2.төлөвлөгөөт бус хайгуул, устгалын ажил гүйцэтгэхтэй холбогдон гарсан зардлыг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэх;

5.2.3.гэнэтийн тохиолдол үүссэн үед анхан шатны эмнэлгийн тусламж үзүүлэх бүлгийг томилон ажиллуулах, гэмтэж шархадсан иргэнийг татан гаргах.

5.3. Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллага (газар, хэлтэс, хэсэг)-ын эрх, үүрэг

5.3.1.хайгуул, устгалын бүлгийг ирэх хүртэл тэсэрч, дэлбэрэх аюул бүхий зүйлийг хяналтад авч, болзошгүй аюулаас сэргийлэн хязгаарлалт тогтоох;

5.3.2.тэсэрч дэлбэрэх зүйл илэрсэн газар орон, объектын хамгаалалтыг зохион байгуулж, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг зохицуулж, аюултай зүйлийг тойрох тэмдэг, тэмдэглэгээ байрлуулах;

5.3.3.шаардлагатай тохиолдолд хайгуул, устгалын бүлгийг байрлуулах, хүн техникээр дэмжлэг үзүүлж, мэдээ, мэдээлэл цуглуулах, нэгтгэх, солилцох;

5.3.4.тэсэрч, дэлбэрэх зүйл илэрсэн буюу осол гарсан тохиолдолд байршлыг хамгаалалтад авч, хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгийг хамгаалах, нүүлгэн шилжүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

5.3.5.гэнэтийн тохиолдол үүссэн үед эмнэлгийн анхан шатны эмнэлгийн тусламж үзүүлэх, эмнэлгийн байгууллагад шуурхай мэдэгдэх.

5.4. Иргэн, хуулийн этгээдийн эрх, үүрэг

5.4.1.тэсэрч, дэлбэрэх зүйл илэрсэн тухай мэдээллийг тухайн орон нутгийн Цагдаагийн эсхүл Онцгой байдлын байгууллагад мэдэгдэх;

5.4.2.тэсэрч, дэлбэрэх зүйл илэрсэн газар оронд Цагдаагийн байгууллагын алба хаагчид ирэх хүртэл аюулгүй байдлыг хангах талаар боломжит арга хэмжээг авах;

5.4.3.цэргийн зориулалтай тэсэрч, дэлбэрэх зүйлийг олж мэдсэн талаар үнэн зөв мэдээллийг холбогдох байгууллагад мэдээлэх.

Зургаа. Хайгуул, устгалын ажлын зардал, санхүүжилт

6.1. Зэвсэгт хүчний Жанжин штаб нь Зэвсэгт хүчний тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.10-т заасны дагуу цэргийн зориулалттай тэсэрч, дэлбэрэх зүйлийг аюулгүй болгохтой холбогдсон зардлыг тухайн жилийн төсөвт тусгаж, хуульд заасан хугацаанд Батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлж шийдвэрлүүлнэ.

6.2. Хайгуул, устгалын ажилд шаардлагатай тусгай зориулалтын техник, сапёрчны хамгаалах хувцас, зайнаас илрүүлэх хэрэгсэл, эрэлч нохой, робот сапёр, бусад багаж, тоног төхөөрөмжийг худалдан авах зардлыг улсын төсөвт үе шаттайгаар тусгаж шийдвэрлүүлнэ.

6.3. Төлөвлөгөөт хайгуул, устгалын ажил гүйцэтгэх зардлыг улсын төсвөөс санхүүжүүлэх ба энэ журмын хоёрдугаар хавсралтад заагдсан зардлын тооцоолол

болон гуравдугаар хавсралт дахь ажлын болон зарцуулах галт хэрэглэлийн үнэлгээг тус тус баримтлан зардлыг тооцоолно.

6.4. Төлөвлөгөөт бус хайгуул, устгалын ажилд зарцуулах зардлыг хоёрдугаар хавсралтад заагдсан зардлын тооцоолол болон гуравдугаар хавсралтад заагдсан ажлын болон зарцуулах галт хэрэглэлийн үнэлгээг баримтлан тооцож Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, байгууллагын төсөв болон холбогдох хуулийн этгээдээс гаргаж санхүүжүүлнэ.

6.5. Энэ журмын 4.7, 4.8-д заасан болон төлөвлөгөөт бус хайгуул, устгалын ажлын үйл ажиллагаанаас олсон орлогыг Зэвсэгт хүчний төрийн сангийн дансанд төвлөрүүлж, инженерийн галт хэрэглэлийг нөхөн бүрдүүлэх, хайгуул, устгалын ажлыг гүйцэтгэх томилгоот бүлгүүдийн үүрэг гүйцэтгэх чадавхыг нэмэгдүүлэхэд зарцуулна.

Долоо. Хайгуул, устгалын ажлын гүйцэтгэлд тавих хяналт

7.1. Зэвсэгт хүчний Хяналт-шинжилгээ, үнэлгээний газар хайгуул, устгалын ажил гүйцэтгэх үед болон үйл ажиллагаанд хяналт тавина.

7.2. Аймаг, нийслэл (дүүрэг)-ийн Засаг даргын Тамгын газрын даргын тушаалаар байгуулагдсан Цэргийн штаб, төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын төлөөлөл бүхий ажлын хэсэг хяналт тавьж, хайгуул, устгалын ажлын талбай, ажил гүйцэтгэсэн актыг хүлээн авна.

7.3. Иргэдийн хүсэлт, мэдээллийн дагуу төлөвлөгөөт бус хайгуул устгалын ажлыг зохион байгуулах тохиолдолд Зэвсэгт хүчний Жанжин штабын даргын тушаалаар мэргэжлийн удирдлагаар хангах, шалган туслах, хянах үүрэг бүхий албан тушаалтанг тухай бүр томилон ажиллуулна.

Найм. Хориглох зүйл

8.1. Уул уурхайн болон иргэний зориулалттай тэсэрч, дэлбэрэх зүйлийг хайгуул, устгалын бүлгүүдээр устгуулахыг хориглоно.

---oOo---

ЦЭРГИЙН ЗОРИУЛАЛТТАЙ ТЭСЭРЧ, ДЭЛБЭРЭХ ЗҮЙЛИЙГ АЮУЛГҮЙ
БОЛГОЖ УСТГАСАН ТУХАЙ АКТ (загвар)

ЗХЖШ-ын даргын 20... оны ... дугаар сарын ... -ны өдрийн ... дугаар тушаалаар
томилогдсон:

Хайгуул устгалын бүлгийн дарга:

(албан тушаал, цол, овог, нэр)

Бүлгийн бүрэлдэхүүн:

(мөн төрийн захиргаа, төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын
төлөөллийн албан тушаал, цол, овог, нэр)
бүрэлдхүүнтэй бүлэг

(Хэн илрүүлсэн, хэдийд хэнд мэдэгдсэн, мэдээллийн мөрөөр ямар арга
хэмжээ авсан)

Илэрсэн зүйлийн зориулалт, үйлдвэрлэгдсэн он, тоо хэмжээ, төрөл хамаарал,
чанар байдал:

д/д	Тэсэрч, дэлбэрэх зүйлийн нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Зориулалт	Үйлдвэрлэгдсэн он	Тайлбар (Төрөл хамаарал, чанар байдлын талаар дэлгэрэнгүй бичнэ)
1						

Илэрсэн зүйлийг 20 ... оны дугаар сарын ... -ны өдөр аюулгүйн
ажиллагааны зааврын дагуу

(устгал хийсэн хийсэн газар, ямар арга хэрэгслээр аюулгүй болгосон)
аюулгүй болголоо.

Зардлын тооцоог Батлан хамгаалахын сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайдын
2023 оны ... дугаар хамтарсан тушаалын хоёрдугаар хавсралтаар батлагдсан
“Төлөвлөгөөт бус хайгуул, устгалын ажилд зарцуулах зардлын тооцоолол” болон
мөн тушаалын гуравдугаар хавсралтаар батлагдсан “Цэргийн зориулалттай тэсэрч,
дэлбэрэх зүйлийн хайгуул, устгалын ажилд зарцуулах галт хэрэглэлийн үнэлгээ”-г
тус тус үндэслэн тооцож, санхүүгийн анхан шатны баримтыг хавсаргана. Үүнд:

- Хайгуул, устгалын ажлын хөлс төгрөг;
- Тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн үнэ төгрөг;
- Шатахуун, тос, тосолгооны материалын үнэ төгрөг;
- Бие бүрэлдэхүүний томилолтын зардал төгрөг;
- Бусад зардал төгрөг;
- Нийт зардал төгрөг.

Цаашид авах арга хэмжээ, анхаарах асуудал, санал:

Хайгуул, устгалын ажил гүйцэтгэсэн тухай дүгнэлт:

(гэрэл зураг, дүрс бичлэг, бүдүүвч, зураглал хавсаргана)

Хайгуул, устгалын бүлгийн дарга:

(албан тушаал, цол, овог, нэр)

Бүлгийн бүрэлдэхүүн:

(албан тушаал, цол, овог, нэр)

Хайгуул, устгалын ажил гүйцэтгэхэд байлцсан төрийн захиргаа, төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын төлөөлөл:

(албан тушаал, цол, овог, нэр, гарын үсэг)

Актыг ... хувь үйлдэв.

I хувийг _____

II хувийг _____

III хувийг _____

ТӨЛӨВЛӨГӨӨТ БУС ХАЙГУУЛ, УСТГАЛЫН АЖИЛД ЗАРЦУУЛАХ ЗАРДЛЫН ТООЦООЛОЛ

Төлөвлөгөөт бус хайгуул, устгалын ажилд зарцуулах зардлын тооцоолол нь инженерийн галт хэрэглэл, тээвэрлэлт, бие бүрэлдэхүүний албан томилолт, даатгал, цалингийн нэмэгдэл, техник, багаж, тоног төхөөрөмж, хүнсний дараах зардлуудаас бүрдэнэ:

1. Инженерийн галт хэрэглэлийн зардалд – Нэг бүлэгт 75 кг тэсрэх бодис, 100 ширхэг капсуль детонатор, 25 ширхэг цахилгаан детонатор, 50 метр тэсрэх шижим, 75 метр гал дамжуулах шижимтэй байхаар;

2. Тээвэрлэлтийн зардалд - Бүлгийн тээврийн хэрэгслийн нэг сард 150 км явж үүрэг гүйцэтгэх шатахуун, тосолгооны материал, сэлбэгээр хангахаар;

3. Бие бүрэлдэхүүний албан томилолтын зардалд - Хайгуул, устгалын ажилд томилогдсон алба хаагчид албан томилолт олгохоор;

4. Даатгалын зардалд – Хайгуул, устгалын ажилд томилогдсон алба хаагчийг гэнэтийн ослын даатгал, жолоочийг жолоочийн хариуцлагын даатгалд, тээврийн хэрэгслийг тээврийн хэрэгслийн даатгалд хамруулахаар;

5. Цалингийн нэмэгдлийн зардалд - Хайгуул, устгалын ажилд томилогдсон алба хаагчийн болон тухайн ажлыг удирдахаар томилогдсон цэргийн алба хаагчийн цалингийн онцгой нөхцөлийн нэмэгдлийг ажилласан хугацаанд нь 40 хувиар тооцож олгохоор;

6. Техник, багаж, тоног төхөөрөмжийн зардалд - Хайгуул, устгалын ажилд шаардлагатай техник, багаж, тоног төхөөрөмжийг үйлчилгээ, засвар хийх, сольж шинэчлэхээр;

7. Хүнсний зардалд - Хайгуул, устгалын ажилд томилогдсон алба хаагчид хугацаат цэргийн алба хаагчийн хүнсний 1 дүгээр нормоор сард 5 өдөр үүрэг гүйцэтгэхээр, эрэлч нохойд тусгай зориулалтын хүнсээр тогтмол хангахаар тооцох зардал зэрэг орно.

**ЦЭРГИЙН ЗОРИУЛАЛТТАЙ ТЭСЭРЧ, ДЭЛБЭРЭХ ЗҮЙЛИЙН ХАЙГУУЛ,
УСТГАЛЫН АЖЛЫН БОЛОН ЗАРЦУУЛАХ ГАЛТ ХЭРЭГЛЭЛИЙН ҮНЭЛГЭЭ**

1. Хайгуул, устгалын ажлын үнэлгээ

Д/д	Ажлын нэр	Хэмжих нэгж	Ажлын үнэлгээ (төгрөг)
Нэг. Тэсэрч, дэлбэрэх зүйлийг хайн илрүүлэх			
1	Талбайд ил үзлэг	м.кв	2,570.00
2	Минэ эрэгчээр 15-40 см хүртэл гүнд хайгуул хийх	м.кв	5,125.00
3	Тэсрэх аюул бүхий зүйлийг газраас ухаж гаргах	ширхэг	11,200.00
4	Тэсрэх аюул бүхий зүйлийг машины тэвшинд ачих	ширхэг	1,200.00
5	Тэсрэх аюул бүхий зүйлийг машины тэвшнээс буулгах	ширхэг	1,000.00
Хоёр. Тэсэрч, дэлбэрэх зүйлийг тэсэлгээний аргаар аюулгүй болгох			
1	5,11-14,5 мм-ийн буудлагын зэвсгийн сум	ширхэг	1,750.00
2	23-57 мм хүртлэх зенитийн буудлагын зэвсгийн сум	ширхэг	42,000.00
3	100 мм хүртлэх артиллер, миномётын сум, минэ	ширхэг	68,000.00
4	100 мм-ээс дээш калибртай артиллерийн сум, минэ	ширхэг	84,000.00
5	Онгоцны бөмбөг	ширхэг	92,000.00
6	Танк эсэргүүцэх минэ	ширхэг	42,000.00
7	Явган цэрэг эсэргүүцэх минэ	ширхэг	95,000.00
8	Бүх төрлийн гранат	ширхэг	36,000.00
Гурав. Тэсэрч, дэлбэрэх зүйлийг устгах газар орныг бэлтгэх			
1	Тэсэрч, дэлбэрэх зүйлсийг тэслэж устгах нүх ухах	м.куб	50,000.00

2. Тэсэрч, дэлбэрэх зүйлийг тэсэлгээний аргаар устгахад шаардлагатай инженерийн галт хэрэглэлийн үнэлгээ

Д/д	Галт хэрэглэлийн төрөл	Хэмжих нэгж	Нэг бүрийн үнэ (төгрөг)
1	Тэсрэх бодис (тротил)	кг	80,000.00
2	Капсюль детонатор	ширхэг	16,000.00
3	Цахилгаан детонатор	ширхэг	20,000.00
4	Тэсрэх шижим	метр	10,000.00
5	Гал дамжуулах шижим	метр	4,000.00

Тайлбар: Ажлын болон зарцуулах галт хэрэглэлийн үнэлгээг тухайн жилийн валютын ханш, импортын ижил нэрийн бараа, материал, галт хэрэглэлийн үнийн өсөлттэй уялдуулан тооцно.